**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/246/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа<br>Утас: 99108763, Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 275

танай ______________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
Г.БАТДОРЖ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,032.6 сая төгрөгийн залруулаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан соёл, урлаг, аялал жуулчлал, олон нийтийг хамарсан 30 гаруй нэр төрлийн арга хэмжээнд 7,531.2 сая төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн Соёл урлагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж уг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

1426050107
C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

**Аудитын гол асуудал**

Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах зардлаас бэлтгэсэн 585.1 сая төгрөгийн бараа материалыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 97.5 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **503,028,472.28** | **1,278,159,663.32** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **1,500,000.00** | **1,500,000.00** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **1,500,000.00** | **1,500,000.00** |
| **3121** | **Төгрөг** | **1,500,000.00** | **1,500,000.00** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **33** | **АВЛАГА** | **1,877,313.28** | **-** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 305,489.84 | - |
| 33402 | Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ | 1,481,823.44 | - |
| **335** | **Бусад авлага** | **90,000.00** | **-** |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 90,000.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **27,000,000.00** | **27,000,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 27,000,000.00 | 27,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **472,651,159.00** | **1,249,659,663.32** |
| **354** | **Хангамжийн материал** | **472,651,159.00** | **1,249,659,663.32** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 79,000.00 | 79,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,074,149.00 | 25,592,149.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 538,000.00 | 538,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 452,960,010.00 | 1,223,450,514.32 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **276,571,302.37** | **342,309,326.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **276,571,302.37** | **342,309,326.90** |
| 392 | Биет хөрөнгө | 276,571,302.37 | 342,309,326.90 |
| 39201 | Барилга, байгууламж | 6,166,785.44 | 6,166,785.44 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (2,398,194.54) | (3,083,392.98) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 386,375,670.00 | 479,228,770.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (210,735,907.16) | (240,500,420.31) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 90,404,181.96 | 109,363,401.96 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,172,511.09) | (37,257,094.93) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 55,923,500.00 | 55,923,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (19,992,222.24) | (27,532,222.28) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **779,599,774.65** | **1,620,468,990.22** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **5,192,829.99** | **6,439,966.59** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **5,192,829.99** | **6,439,966.59** |
| **413** | **Өглөг** | **5,192,829.99** | **6,439,966.59** |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 542,899.99 | 74,941.59 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 149,930.00 | 842,025.00 |
| **4136** | **Бусад өглөг** | **4,500,000.00** | **5,523,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,500,000.00 | 5,523,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **774,406,944.66** | **1,614,029,023.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **774,406,944.66** | **1,614,029,023.63** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан** | **261,759,011.80** | **261,759,011.80** |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 261,759,011.80 | 261,759,011.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **511,995,538.30** | **1,351,617,617.27** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 511,995,538.30 | 511,995,538.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 839,622,078.97 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 652,394.56 | 652,394.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **779,599,774.65** | **1,620,468,990.22** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **11,087,631,250.00** | **9,412,218,492.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **142,709,180.00** | **696,926,324.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **142,709,180.00** | **696,926,324.32** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 142,709,180.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 142,709,180.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан - Үндсэн хөрөнгө | - | 111,812,320.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан - Бараа материал | - | 585,114,004.32 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,944,922,070.00** | **8,715,292,168.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **744,338,100.00** | **972,163,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 744,338,100.00 | 972,163,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,200,583,970.00** | **7,743,128,868.00** |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 5,948,484,481.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 4,252,099,489.00 | 7,743,128,868.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **10,880,577,148.30** | **8,572,596,413.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,880,577,148.30** | **8,572,596,413.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **9,719,065,151.02** | **8,321,562,589.33** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **387,512,957.21** | **563,282,167.08** |
| 210101 | Цалин | 230,955,140.68 | 311,588,684.71 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 88,193,116.53 | 81,644,453.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,127,000.00 | 121,363,000.00 |
| 210104 | Урамшуулал | 34,237,700.00 | 48,686,028.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **49,694,415.22** | **71,322,138.42** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 34,344,923.03 | 49,117,678.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,723,771.24 | 5,551,114.94 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,956,040.46 | 2,775,557.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,933,936.03 | 2,775,557.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 7,735,744.46 | 11,102,229.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,000,000.00** | **26,136,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 10,000,000.00 | 26,136,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,534,200.65** | **70,737,710.16** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 5,908,052.00 | 4,594,895.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 5,992,945.00 | 60,564,300.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 2,034,803.65 | 1,608,365.16 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 3,047,800.00 | 3,970,150.00 |
| 210408 | Бараа материал актасны зардал | 4,550,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **8,144,641,421.00** | **4,437,364,537.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,140,861,421.00 | 4,433,341,537.20 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 780,000.00 | 1,023,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,105,682,156.94** | **3,152,720,036.47** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,092,074,300.00 | 3,015,795,441.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 4,994,000.00 | 90,850,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 8,613,856.94 | 46,074,295.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,161,511,997.28** | **251,033,824.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **19,203,343.33** | **85,600,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,203,343.33 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,000,000.00 | 85,600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 66,888,769.95 | 165,261,734.22 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг (үндсэн данс) | 66,888,769.95 | 165,261,734.22 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг (нэмэлт данс) | 1,075,419,884.00 | 172,089.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **207,054,101.70** | **839,622,078.97** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **3,148,625.49** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 650,000.14 | - |
| 225010 | Актны төлбөр торгууль | 2,498,625.35 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **(3,148,625.49)** | **-** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **203,905,476.21** | **839,622,078.97** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **11,938,772,070.00** | **8,715,687,657.84** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **993,850,000.00** | **305,489.84** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **993,850,000.00** | **305,489.84** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 305,489.84 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 305,489.84 |
| 120009 | Бусад орлого | 993,850,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,944,922,070.00** | **8,715,382,168.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **744,338,100.00** | **972,163,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 744,338,100.00 | 972,163,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,200,583,970.00** | **7,743,218,868.00** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 5,948,484,481.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 4,252,099,489.00 | 7,743,218,868.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **10,853,994,280.00** | **8,715,687,657.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,853,994,280.00** | **8,715,687,657.84** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **9,692,482,282.72** | **8,464,653,833.82** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **388,285,627.32** | **562,343,243.63** |
| 210101 | Үндсэн цалин | 231,727,810.79 | 310,106,861.27 |
| 210102 | Нэмэгдэл | 88,193,116.53 | 82,187,353.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,127,000.00 | 121,363,000.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 34,237,700.00 | 48,686,028.50 |
| **2102** | **Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **52,664,783.75** | **71,247,196.83** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 37,006,190.56 | 49,042,437.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 4,032,872.24 | 5,551,114.94 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,956,040.46 | 2,775,557.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,933,936.03 | 2,775,557.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 7,735,744.46 | 11,102,529.67 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **10,000,000.00** | **25,528,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 10,000,000.00 | 25,528,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,430,870.65** | **70,780,115.16** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,908,052.00 | 4,594,895.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,992,945.00 | 60,564,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,884,873.65 | 1,524,270.16 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,645,000.00 | 4,096,650.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,125,577,901.00** | **4,483,409,537.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 8,121,009,901.00 | 4,480,409,537.20 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,700,000.00 | 3,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 868,000.00 | - |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 1,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,097,523,100.00** | **3,251,345,741.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,092,529,100.00 | 3,160,495,441.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 4,994,000.00 | 90,850,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,161,511,997.28** | **251,033,824.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **19,203,343.33** | **85,600,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,203,343.33 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,000,000.00 | 85,600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **66,888,769.95** | **165,433,824.02** |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг (үндсэн данс) | 66,888,769.95 | 165,261,734.22 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг (нэмэлт данс) | - | 172,089.80 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,075,419,884.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,075,419,884.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,084,777,790.00** | **-** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **91,927,790.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **91,927,790.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **91,927,790.00** | **-** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 91,927,790.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(91,927,790.00)** | **-** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **992,850,000.00** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,500,000.00** | **1,500,000.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,500,000.00** | **1,500,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **261,759,011.80** | **652,394.56** | **308,090,062.09** | **570,501,468.45** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 261,759,011.80 | 652,394.56 | 308,090,062.09 | 570,501,468.45 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 203,905,476.21 | 203,905,476.21 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **261,759,011.80** | **652,394.56** | **511,995,538.30** | **774,406,944.66** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 261,759,011.80 | 652,394.56 | 511,995,538.30 | 774,406,944.66 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 839,622,078.97 | 839,622,078.97 |
| **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **261,759,011.80** | **652,394.56** | **1,351,617,617.27** | **1,614,029,023.63** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,013,509,300.00** | **807,207,055.62** | **206,302,244.38** | **79.6** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,013,509,300.00** | **806,901,565.78** | **206,607,734.22** | **79.6** |
| **131001** | **Улсын төсвөөс санхүүжих** | **1,013,509,300.00** | **806,901,565.78** | **206,607,734.22** | **79.6** |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **-** | **305,489.84** | **(305,489.84)** | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 305,489.84 | (305,489.84) | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,013,509,300.00** | **807,207,055.62** | **206,302,244.38** | **79.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,013,509,300.00** | **807,207,055.62** | **206,302,244.38** | **79.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,012,909,300.00** | **806,607,055.62** | **206,302,244.38** | **79.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **709,812,700.00** | **562,343,243.63** | **147,469,456.37** | **79.2** |
| 210101 | Үндсэн цалин | 353,730,600.00 | 310,106,861.27 | 43,623,738.73 | 87.7 |
| 210102 | Нэмэгдэл | 149,003,400.00 | 82,187,353.86 | 66,816,046.14 | 55.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 158,130,200.00 | 121,363,000.00 | 36,767,200.00 | 76.7 |
| 210104 | Урамшуулал | 48,948,500.00 | 48,686,028.50 | 262,471.50 | 99.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **88,726,700.00** | **71,247,196.83** | **17,479,503.17** | **80.3** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,334,100.00 | 49,042,437.18 | 11,291,662.82 | 81.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,098,100.00 | 5,551,114.94 | 1,546,985.06 | 78.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,549,100.00 | 2,775,557.52 | 773,542.48 | 78.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,549,100.00 | 2,775,557.52 | 773,542.48 | 78.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,196,300.00 | 11,102,529.67 | 3,093,770.33 | 78.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **25,534,600.00** | **25,528,000.00** | **6,600.00** | **100.0** |
| 210304 | Байрны түрээс | 25,534,600.00 | 25,528,000.00 | 6,600.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,332,000.00** | **11,415,815.16** | **2,916,184.84** | **79.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,984,500.00 | 4,594,895.00 | 1,389,605.00 | 76.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,154,800.00 | 1,524,270.16 | 630,529.84 | 70.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,992,700.00 | 4,096,650.00 | 896,050.00 | 82.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **171,085,200.00** | **133,650,000.00** | **37,435,200.00** | **78.1** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 164,750,000.00 | 130,650,000.00 | 34,100,000.00 | 79.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,990,900.00 | 3,000,000.00 | 1,990,900.00 | 60.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,344,300.00 | - | 1,344,300.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,418,100.00** | **2,422,800.00** | **995,300.00** | **70.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,567,800.00 | 1,572,500.00 | 995,300.00 | 61.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 850,300.00 | 850,300.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **600,000.00** | **600,000.00** | **-** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **600,000.00** | **600,000.00** | **-** | **100.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 | - | 100.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **1,500,000.00** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **1,500,000.00** | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **14** | **14** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13 | 13 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **7,743,218,868.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **7,743,218,868.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 7,743,218,868.00 |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **7,743,218,868.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **7,743,218,868.00** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **-** | **7,658,046,778.20** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 59,364,300.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | - | 59,364,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **-** | **4,349,759,537.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 4,349,759,537.20 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **3,248,922,941.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 3,158,922,941.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 90,000,000.00 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **85,172,089.80** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **85,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | - | 85,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **172,089.80** |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг (нэмэлт данс) | - | 172,089.80 |

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 гүйлгээний 1,049,935.7 мянган төгрөг, зарлагын 16 гүйлгээний 362,490.0 мянган төгрөг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг огт байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.2.1, 6.10 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 13,270,377.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Нэмэлт санхүүжилтийн данснаас НЗДТГ-ын дансанд шилжүүлсэн 228,695.9 мянган төгрөгийг санхүүжилт болон төвлөрүүлэх шилжүүлгийн зардалд давхар бүртгэсэн ;
- Нэмэлт санхүүжилтийн тайлангийн хөтөлбөр, арга хэмжээ, зардлын ангиллыг 2,665,264.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардал нь мөнгөн гүйлгээний тайлангийн цалингийн зардлаас 938.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь мөнгөн гүйлгээний тайлангийн ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 74.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн шилжүүлэн авсан 111,812.3 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд бүртгээгүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд бараа үйлчилгээний бусад зардалд 1,572.5 мянган төгрөгийг дутуу бүртгэсэн;
- Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүн үр дүнгийн тайлангийн дүнгээс 206,016.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Үндсэн болон нэмэлт дансны орлого, зарлагын гүйлгээний үлдэгдэл 8,941,877.0 мянган төгрөгийг төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Санхүүгийн байдлын тайлангийн бичиг хэргийн материалын үлдэгдэл нь бараа материалын тодруулга тайлангийн үлдэгдлээс 3.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн 1,013,509.3 мянган төгрөгийн төлөвлөгөөг бүртгээгүй;

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 1200045 дансанд 100,612.4 мянган төгрөг бүртгэж тайлагнасныг

Эдгээр нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т *“Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх*” болон санхүүгийн тайлагналын “үнэн зөв *байх*”, “*толилуулга*” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,032,549.9 мянган төгрөгийн 6 зөрчил[2] илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил нь бидний тогтоосон 108,805.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.
**Албан шаардлага**

1.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах зардлаас худалдан авсан 585,114.0 мянган төгрөгийн бараа материалыг Нийслэлийн засаг даргын тамгын газраас шилжүүлэн өгсөн боловч байгууллагад биетээрээ ирээгүй, бараа материал хүлээлцсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 19 дүгээр зүйлийн 19.1-т “*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*”, 20 дугаар зүйлийн 20.1.1-т “*нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*”; гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Бараа материалыг хүлээлцсэн акт үйлдээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Урьдчилж төлсөн зардлын 27,000.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Тооцоо нийлсэн акт үйлдээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал*

***Илрүүлэлт-1*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 174 ширхэг 243,286.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” 7.1-д “*төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

**Илрүүлэлт-2:** Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дүнгээс 585,114.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "*комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх*" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *“холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Үндсэн хөрөнгийн тооллогын тооцоог бодож, хөрөнгийн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж тооцоо бодож тайлагнах.

**5.2.2** *Бараа материалын данстай холбоотой асуудал*

**Илрүүлэлт-3:** Бараа материалын тайланг материалын нэр төрөл, тоо хэмжээгээр гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 20.1.4-т “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж*:*** Бараа материалын тайланг иж бүрэн бэлтгэн гаргах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

***Санхүүгийн тайлантай холбоотой асуудал***

***Илрүүлэлт-4:*** Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5 Санхүүгийн тайлангийн тодруулга*", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*"-ын 8.3-т "*Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг бэлтгэж байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** *\/мянган төгрөгөөр/*

| Д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан шилжүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зардлыг буруу ангилан бүртгэсэн; | 1 | 228,695.9 | | | 1 | 228,695.9 | 1 | 228,695.9 | | |
| 2 | Нэмэлт санхүүжилтийн тайланг 2,665,264.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн. | 1 | 2,665,264.0 | | | 1 | 2,665,264.00 | 1 | 2,665,264.0 | | |
| 3 | Цалингийн зардлыг тайлангууд хооронд 938.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн; | 1 | 938.9 | | | 1 | 938.90 | 1 | 938.9 | | |
| 4 | А/О НДШ-ийн зардлыг тайлангууд хооронд 74.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн; | 1 | 74.9 | | | 1 | 74.90 | 1 | 74.9 | | |
| 5 | Шилжүүлэн авсан 111,812.3 мянган төгрөгийн хөрөнгийг тайланд бүртгээгүй; | 1 | 111,812.3 | | | 1 | 111,812.30 | 1 | 111,812.3 | | |
| 6 | Бараа, үйлчилгээний бусад зардлыг 1,572.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн; | 1 | 1,572.5 | 1 | 1,572.5 | | | 1 | 1,572.5 | | |
| 7 | Тайлант үеийн үр дүнг тайлангууд хооронд 206,016.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн; | 1 | 206,016.5 | | | 1 | 206,016.50 | 1 | 206,016.5 | | |
| 8 | Дансны орлого, зарлага, үлдэгдлийг 8,941,877.0 мянган төгрөгөөр төрийн сантай баталгаажуулаагүй; | 1 | 8,941,877.0 | | | 1 | 8,941,877.00 | 1 | 8,941,877.0 | | |
| 9 | Бичиг хэргийн материалын үлдэгдлийг 3.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн; | 1 | 3.6 | | | 1 | 3.60 | 1 | 3.6 | | |
| 10 | Төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,013,509.3 мянган төгрөгийн санхүүжилтийн төлөвлөгөөг бүртгээгүй; | 1 | 1,013,509.3 | 1 | 1,013,509.3 | | | 1 | 1,013,509.3 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Санхүүгийн үр дүнгийн тайланд 1200045 дансанд 100,612.3 мянган төгрөг бүртгэсэн | 1 | 100,612.4 | | | 1 | 100,612.4 | 1 | 100,612.4 | | |
| | **Дүн** | **11.0** | **13,270,377.3** | **2.0** | **1,015,081.8** | **9.0** | **12,255,295.5** | **11.0** | **13,270,377.3** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

***/мянган төгрөгөөр/***

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | 585,114.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан боловч биетээрээ хүлээн аваагүй, акт үйлдээгүй. | 1 | 585,114.0 | - | - | 1 | 585,114.0 | | | | | | |
| 2 | Урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг харилцагчтай тооцоо хийж баталгаажуулаагүй | 1 | 27,000.0 | - | - | 1 | 27,000.0 | | | | | | |
| 3 | 174 ширхэг 243,286.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй. | 1 | 243,286.9 | - | - | | | 1 | 243,286.9 | | | | |
| 4 | Үндсэн хөрөнгийн тооллогын дүн үндсэн хөрөнгийн дүнгээс 585,114.0 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |
| 5 | Бараа материалын тайланг материалын нэр төрөл, тоо хэмжээгээр гаргаагүй | 1 | 177,149.0 | - | - | | | 1 | 177,149.0 | | | | |
| 6 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй | | | | | | | | | | | | |
| | **Дүн** | **6** | **1,032,549.9** | **-** | **-** | **2** | **612,114.0** | **4** | **420,435.9** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 гүйлгээний 1,049,935.7 мянган төгрөг, зарлагын 16 гүйлгээний 362,490.0 мянган төгрөг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 1,412,425.7 | - | - | 1 | 1,412,425.7 | - | - |
| **Дүн** | **1** | **1,412,425.7** | **-** | **-** | **1** | **1,412,425.7** | **-** | **-** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 73/2081/0579 Улаанбаатар хот

НТАГ-2026/246/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьдчилан төлсөн зардлын 27,000,000.00 (хорин долоон сая) төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.7-д "*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тооцооны дансны үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батдорж, нягтлан бодогч М.Норжмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

1426090131

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 74/20810579 Улаанбаатар хот

НТАГ-2026/246/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 гүйлгээний 1,049,935,700.00 (*нэг тэрбум дөчин есөн сая есөн зуун гучин таван мянга долоон зуу*) төгрөг, зарлагын 16 гүйлгээний 362,490,00.00 (*гурван зуун жаран хоёр сая дөрвөн зуун ерэн мянга*) төгрөг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*", 6.10-т "*Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.10 "*аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*", 4.2.1.11 "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батдорж, нягтлан бодогч М.Норжмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

1426090135

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 73/20810579 Улаанбаатар хот

НТАГ-2026/246/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах зардлаас 585,114,004.00 (таван зуун наян таван сая нэг зуун арван дөрвөн мянга дөрөв) төгрөгийн бараа материалыг худалдан авахдаа хүлээлцсэн акт үйлдээгүй ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 19 дүгээр зүйлийн 19.1-т "*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*", 20 дугаар зүйлийн 20.1.1-т "*нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.1-т "*нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа материал хүлээлцсэн акт үйлдээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батдорж, нягтлан бодогч М.Норжмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

1426090133